

18 Мессиа Эхний Ирэлтийн үед үзэн ядагдах тухай эш үзүүлэг

18.1 Үзэн ядагдаж, үл тоомсорлогдсон

¹⁰Гэвч Түүнийг няцалж, өвтгөх нь ЭЗЭНий таалал байв. Хэрэв Тэр Өөрийгөө нүглийн төлөөх тахил болгон өргөвөл, Тэр үр удмаа үзэж, Өөрийн өдрүүдийг уртасган, ЭЗЭНий хүсэл нь Түүний гарт цэцэглэх болно. (Исаиа 55:10 АБ 2004)

¹⁰Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй. ¹¹Тэр өөрийнхөндөө ирсэн боловч, өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй. (Иохан 1:10-11 АБ 2004)

⁵Есүсийн дүү нар нь хүртэл Түүнд итгээгүй байжээ. ⁴⁸Захирагчид болон фарисайчуудаас хэн ч Түүнд итгээгүй биз дээ? (Иохан 7:5/48 АБ 2004)

¹³Хуу татахаар архиран байгаа арслан шиг Тэд над уруу амаа том ангайлгадаг. (Дуулал 22:13 АБ 2004)

⁶Харин би бол өт, хүн биш! Би бол хүмүүсийн буруутгал бөгөөд ард олонд жигшигдсэн юм. (Дуулал 22:6 АБ 2004)

¹⁰Намайг мацаг барин сэтгэлдээ уйлахад, Тэр нь чухамдаа миний шившиг болсон. (Дуулал 69: 10 АБ 2004)

⁷Үндэстнүүдэд үзэн ядагдсан, басамжлагдсан Нэгэн болох захирагчдын зарцад хандан Израилийн Аврагч, түүний Ариун Нэгэн, ЭЗЭН ингэж айлдаж байна. “Чамайг сонгосон Израилийн Ариун Нэгэн, итгэмжит ЭЗЭНээс болж хаад үзээд босно, ноёд ч мөн бөхийнө”. (Исаиа 49: 7 АБ 2004)

³Тэр үзэн ядагдаж, хүмүүсээр орхигдов. Тэр уй гашууны хүн бөгөөд өвчин зовлонг мэдсэн. Бид нүүрээ Түүнээс нуусан. Тэр үзэн ядагдаж, бид Түүнийг хүндэтгээгүй. (Исаиа 53: 3 АБ 2004)

¹Цэргийн бүлгүүдийн охин оо, өөрсдийгөө цэргийн бүлгүүд болгож цуглуул.

Тэд биднийг бүсэлсэн. Тэд саваагаар Израилийн шүүгчийн хацрыг саваадах болно. (Мика 5: 1 АБ 2004)

[] Тэрээр үзэн ядагдахын тулд ирсэн: Та эсэргүүцлийг тэвчиж байна уу? Та мөнхийн алдрыг харж байна уу?

[] Та мөнхөд үргэлжлэх тэр зүйлийг байгуулдаг уу?

[] Есүсийг үзэн ядагдаж, жигшигдэхийг хүчирхэг Бурхан яагаад зөвшөөрсний учрыг та мэдэх үү?

18.2 ЕСҮСИЙГ НАЗАРТ ТАТГАЛЗСАН НЬ

⁵³Есүс эдгээр сургаалт зүйрлэлүүдийг ярьсныхаа дараа тэндээс явав. ⁵⁴Тэр төрөлх хотдоо ирээд, синагогт нь тэднийг сургахад тэд гайхшран-Энэ мэргэн ухаан, эдгээр гайхамшигт хүчийг энэ хүн хаанаас авсан юм бол? ⁵⁵Энэ чинь мужааны хүү биш бил үү? Эхийг нь Мариа, дүү нарыг нь Иаков, Иосеф, Симон, Иуда гэдэг биш бил үү? ⁵⁶Охин дүү нар нь бүгд бидэнтэй хамт байгаа биз дээ? Тэгвэл энэ хүн тэр бүхнийг хаанаас авав? гэцгээв. ⁵⁷Тэд Түүнд гомдов.

Харин Есүс тэдэнд -Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, гэрийнхнээсээ өөр газар л хүндлэгддэг юм гэж айлдав. ⁵⁸Тэдний итгэлгүй байдлаас болж Тэр тэнд олон гайхамшиг үйлдсэнгүй. (Матай 13:53-58 АБ 2004)

[] Бурхан таны төсөөлдгөөс хавьгүй өргөн, гүнзгий, агуу гэдэгт та итгэдэг үү?

¹⁸Энэхүү номын эш үзүүлэлийн үгсийг сонсогч бүрд би гэрчилж байна. Хэрэв хэн нэгэн нь эдгээрийн дээр нэмэх аваас, Бурхан энэхүү номд бичигдсэн гамшгуудыг түүнд нэмэх болно. ¹⁹Хэрэв хэн нэгэн нь энэхүү эш үзүүлэлийн номын үгсээс хасах аваас Бурхан энэхүү номд бичигдсэн амийн модноос болон ариун хотоос хувийг нь хасах болно. (Илчлэл 22:18-19 АБ 2004)

[] Та Түүний сургаалыг өөрийнхөөрөө өөрчилдөг үү?

18.3 Тахилчдад Үзэн ядагдсан Мессиа

²²Барилгачдын голсон чулуу Булангийн тулгуур чулуу болов. (Дуулал 118:22 АБ 2004)

⁷Тиймээс итгэгч та нарт энэ нь үнэт. Харин үл итгэгчдэд “Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов” (1 Петр 2:7 АБ 2004)

⁷Үндэстнүүдэд үзэн ядагдсан, басамжлагдсан Нэгэн болох захирагчдын зарцад хандан Израилийн Аврагч, түүний Ариун Нэгэн, ЭЗЭН ингэж айлдаж байна. “Чамайг сонгосон Израилийн Ариун Нэгэн, итгэмжит ЭЗЭНээс болж хаад үзээд босно, ноёд ч мөн бөхийнө”. (Исаиа 49:7 АБ 2004)

[] Есүс Өөрийг нь үгүйсгэнэ гэдгийг мэдэж байсан. Та эсэргүүцлийг тэвчиж чадах уу ?

[] Та нар мөнхийн алдар сууг хүлээн авахыг тэсэн ядан хүлээж байна уу?

[] Та нарын төлөвлөгөө мөнхийн зорилготой юу?

[] Түүнийг жигшигдэж, үзэн ядагдахыг нь мэдсэн мөртлөө хүчирхэг Бурхан Мессиаг илгээсэн шалтгааныг та мэдэх үү?

18.4 Хэн ч хариулахгүй

¹ЭЗЭН ингэж айлдаж байна. “Би эхийг чинь хөөхдөө өгсөн салалтын гэрчилгээ нь хаана байна вэ? Зээлдүүлэгчдийнхээ хэнд нь Би чамайг худалдсан юм бэ? Үзэгтүн, та нар өөрсдийнхөө нүглээс болж худалдагдсан, та нарын эх ч та нарын нүглээс болж хөөгдсөн.

²Намайг ирэхэд яагаад хэн ч байхгүй байв? Намайг дуудахад яагаад хэн ч хариу эс өгүүлэв? Миний мутар золиослон авч чадахааргүй богино юм уу? Эсвэл Надад аврах хүч байхгүй байна уу? Үзэгтүн, Би Өөрийн зэмлэлээр далайг ширгээж, гол мөрнийг говь болгосон. Тэндхийн загас ус дутагдсанаас болж өмхийрөн, цангаж үхнэ. ³Би тэнгэрийг харанхуйгаар хучин, бүтээлийг нь таар болгосон” (Исаиа 50:1-3 АБ 2004)

¹⁵Тийм ээ, үнэн үгүүлэгдэж байна. Бузар муугаас холдогч нь өөрийгөө золиос болгов. ЭЗЭН үүнийг хараад, шударга ёс байхгүй байсанд Түүний мэлмийд таалагдаагүй. ¹⁶Тэнд нэг ч хүн байхгүйг Тэр хараад, тэнд зуучлах хүн нэг ч байхгүйд гайхаж байлаа.Тиймээс Тэр Өөрийн мутраар Түүнд авралыг авчран, Өөрийн зөвөөр Түүнийг дэмжив. ¹⁷Тэр Түүнд үнэн зөвийг хуяг мэт өмсгөн, авралын дуулгыг тэргүүнд нь тавив. Тэр өс хонзон авах хувцсыг өмсөн, зүтгэлээр Өөрийгөө цув мэт ороов. ¹⁸Тэдний хийсэн үйлсийнх нь дагуу Тэр Өөрийн өрсөлдөгчдөд уур хилэн, Өөрийн дайснуудад өшөө хонзон, эргийн нутгуудад зохих хариуг нь өгнө. (Исаиа 59:15-18 АБ 2004)

[] Амьдралаас эрх чөлөө, эрх мэдлийг тань юу холдуулан авч явдгийг та мэдэх үү?

[] Бурхан өмнөх шигээ болон бүр илүүг хийж чадна гэдэгт та итгэдэг үү?

[] Бурханы тэрхүү хүчийг юу зогсоодог болохыг та мэдэх үү?

18.5 Таны өргөөний төлөө хичээл зүтгэлийн улмаас

¹¹Чи тэдэнд “Тэнгэрүүд ба газрыг бүтээгээгүй бурхад газар дэлхийгээс болон тэнгэрүүдийн доороос устах болно” гэж хэл. (Иеримиа 10:11 АБ 2004)

⁹Таны өргөөний төлөө хичээл зүтгэл намайг залгиж, Таныг буруутгасан хүмүүсийн буруутгал надад ирсэн. (Дуулал 69:9 АБ 2004)

[] Газар дэлхий хийгээд түүнд байгаа бүхэн шүүгдэнэ; хуурамч бурхад дагагчид нь аль хэдийн шийтгэл оноогдсон. Та цаг шүүлтийн цаг үеэ мэдэх үү?

[] Та Бурханы өргөөний төлөө бус, харин сайн мэдээний төлөө итгэл үнэмшилтэй байдаг уу?

[] Өөрийн орон гэрийн төлөө зүтгэл (Зөв хашаа– миний зөв гэж бодож байгаа зүйлийг хийх): Библид итгэдэг боловч Сүнсний үйлсийг үгүйсгэдэг.

18.6 Тэр бол Эш үзүүлэгийг биелүүлэгч Нэгэн

Мессиагийн тухай эш үзүүлэг - Бурхангүйгээр биелэх магадлал хэр вэ? Мессиагийн эш үзүүлэг нэг бүрийг нэг Хүн биелүүлэх статистик магадлал Бурханы оролцоогүйгээр 10^{38} . Хэрэв бид Хуучин Гэрээний тодорхой эш үзүүлэгээс Есүс Христээр биелэгдсэн долоон эш үзүүлэгийг авч шинжилбэл ийм түүхэн бодит байдал нь статистикийн хувьд боломжгүй гэдгийг гайхан биширдэг. Жишээ болгон "Тохиолдол" ба долоон эш үзүүлэгийг харуулаа. Та ч бас өөрийн хувьд ирээдүйн магадлал ба өөрийн боломжийг тооцоолж сэтгэл хөдөлгөм тоог бий болгож болох юм!

Мессиагийн тухай эш үзүүлэг нь Библийг бусад “ариун ном” судраас онцгой болгодог гайхамшигтай нотолгоо юм.

Мессиагийн эш үзүүлэг Бурханы оролцоогүй тохиолдол

1.	<u>Есүс Давидын удмынх</u>	10^4 (10000-д 1)
2.	<u>Есүс Бетлехемд төрөх</u>	10^5 (100.000-д 1)
3.	<u>Есүс гайхамшиг үйлдэх</u>	10^5 (100.000-д 1)
4.	<u>Есүс Өөрийгөө илжиг унасан Хаан болгон харуулах</u>	10^6 (1.000.000-д 1)
5.	<u>Есүсийн нэг найз нь гучин мөнгөн зоосны төлөө түүнээс урвах</u>	10^6 (1.000.000-д 1)
6.	<u>Есүс цовдлогдох</u>	10^6 (1.000.000-д 1)
7.	<u>Иерусалимыг дахин сэргээх талаар Артаксеркс хааны зарлигаас хойш 173.880 өдрийн дараа анх удаа Есүс Өөрийгөө Хаан гэж харуулах</u>	10^6 (1.000.000-д 1)

Нийт Магадлал (Бурханы оролцоогүй) 10^{38} (100 тэрбум, тэр бум, тэрбум, тэрбум-д 1)

*Scientific Proof of Accuracy of Prophecy and the Bible By
PETER W. STONER, M.S and ROBERT C. NEWMAN,
STM., Phd. Moody Press Chicago*